



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 14 өдөр

Дугаар А/608

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.4, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 06 дугаар тогтоол, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дөрөвдүгээр хуралдааны 2021 оны "Аймгийн 2021 оны төсвийн тодотгол батлах тухай" 01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.11.1 дэх зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Залуучуудад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг ТББ-уудтай гэрээ байгуулж, Улаанбаатар хот дахь Хэнтий аймгийн оюутан залуучуудад сургалт зохион байгуулах "Hello Khentii" арга хэмжээнд зориулж 5,675,000 (таван сая зургаан зуун далан таван мянган) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231017595

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардал	Нэгжийн үнэ	Тоо	Нийт үнэ
1	Өглөөний цай	30,000	120	3,600,000
2	Анонс хэвлэл үүдний	160,000	1	160,000
3	Туг	160,000	2	320,000
	Индэрийн урдах хэвлэл	30,000	1	30,000
4	Ширээний туг	30,000	3	90,000
5	Батламж бичүүлэх (хавтастайгаа хамт)	15,000	20	300,000
6	Зохион байгуулагч нарын энгэрийн мандат	5,000	15	75,000
7	Оролцогчдийн энгэрийн тэмдэг	110	2,000	220,000
8	Интеризэр зураг бэлдүүлэх (төслийн)	100,000	1	100,000
9	Сонирхлийн бүлгүүдийн танилцуулга, анкет хэвлүүлэх	1,000	100	100,000
10	Санамж бичгийн хавтас	3,000	10	30,000
11	Тэтгэлэгийн зарын постер бэлдүүлэх, бүүстлэх	50,000	1	50,000
12	эх бэлтгэлүүд	20,000	5	100,000
13	Тэтгэлэгийн мөнгө	500,000	1	500,000
Нийт				5,675,000